

ᠳᠣᠷᠨᠣᠳ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ
ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



ДОРНОД АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ

2022 он

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, дүрслэлийн товъёг	4
Зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5-6
Бүлэг 1. Төсвийн орлого, зарлагын хязгаар.....	7-9
Бүлэг 2. Төсвийн орлогын төлөвлөлт.....	9
Бүлэг 3. Төсвийн зарлагын төлөвлөлт.....	10
Бүлэг 4. ТЭЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин	
4.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	10-12
4.2. Хөрөнгө оруулалтын бус төсөл, хөтөлбөр.....	12-13
4.3. Орон нутгийн хөгжлийн сан.....	13-15
Бүлэг 5. Сангийн зардлууд	
5.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал.....	15-16
5.2. Авто замын сан.....	16
5.3. Хөдөө аж ахуйн сан	16 -17
5.4. Халамжийн сан	17- 18
Холбогдох байгууллагын санал	19 -22
Дүгнэлт.....	23
Зөвлөмж	23
Төсвийн төсөлд өгөх санал.....	24
Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаал ..	25

Товчилсон үгийн тайлбар

БОХНСЗ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗЗННТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сангийн яамны орлогын хянасан хязгаар болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын харьцуулалт	7
Хүснэгт 2	Сангийн яамны зарлагын хянасан хязгаар болон төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөсөн зарлагын харьцуулалт	8
Хүснэгт 3	Төсөл арга хэмжээний төсөвт өртгийн өөрчлөлт	11
Хүснэгт 4	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын бус арга хэмжээний хууль, журамд нийцээгүй арга хэмжээний жагсаалт	13
Хүснэгт 5	Хуулиар зөвшөөрсөн зарцуулах хувь, хэмжээ	14
Хүснэгт 6	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн зураг төсөв, тооцоо судалгаагүй арга хэмжээний жагсаалт	16

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сангийн яамны орлогын хянасан хязгаар болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын харьцуулалт	7
Хүснэгт 2	Сангийн яамны зарлагын хянасан хязгаар болон төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөсөн зарлагын харьцуулалт	8
Хүснэгт 3	Төсөл арга хэмжээний төсөвт өртгийн өөрчлөлт	11

Үндэслэл, бүрэн эрх	Зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасны дагуу Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд хийв.
Зорилт	Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн төсөл нь арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, холбогдох шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхийг хангахад зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр санал, дүгнэлтийг гүйцэтгэлээ. Үүнд: Төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх Төсвийн зарлагыг бууруулах Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх.
Хамрах хүрээ	Дорнод аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын холбогдох хэлтсүүдийг хамрууллаа. Аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн 2023 оны жилийн төсвийн төсөл, холбогдох нотлох баримтууд болон тооцоо, судалгааг хамрууллаа.
Шалгуур үзүүлэлт	Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн орон нутгийн 2023 оны төсвийн төсөл нь дараах шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхийг авч үзлээ. Тухайлбал: 1. Төсвийн тухай хууль 2. Төрийн хэмнэлтийн тухай 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж 3. МУЗЗНДНТУТХ 4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 5. Газрын тухай хууль 6. Тариалангийн тухай хууль 7. Нийгмийн халамжийн тухай хууль 8. Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” 9. Сангийн Сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” 10. Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” 11. Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоол “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам” 12. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”

Холбогдох
мэдээлэл

13. Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/01 дугаар тогтоол “Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүрийн хувь, төлбөрийн хэмжээг тогтоох тухай”
14. Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/08 дугаар тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”
15. Холбогдох бусад хууль, журам, заавар

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурт нийцүүлэн төсвийн төслийг **арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж төсвийн зарлагын удирдлагын шинэчлэлийн хүрээнд үр дүн, нотолгоонд суурилсан, оновчтой, үр ашигтай төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх, төсвийн зарлагын шинэчлэлийг үргэлжлүүлж, төсвийн урсгал зардлыг хэмнэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой** байхаар төлөвлөлтийг хийхээр заасан.

Төсвийн удирдлагын үндсэн зарчмууд нь төрийн шийдвэр гаргах болон хянах үе шатуудад гарч болзошгүй эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулах, эсвэл урьдчилан сэргийлэх, чанарыг сайжруулахад чиглэгддэг.

Төсвийн тухай хуулийн 8.5.1 дэх “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх” гэсэн заалттай.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн хамрах хүрээний байгууллагуудын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг онлайнд суурилсан **FISCAL-B** системээр нэгтгэн боловсруулсан байна.

Гүйцэтгэсэн
бүрэлдэхүүн,
хугацаа

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, аудиторууд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Талбарын ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлүүлж, санал, дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга М.Энхтөрд 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүргүүллээ.

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ХЯЗГААР

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Аймгийн төсвийн орлого, зарлагын хязгаарыг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж болон бусад холбогдох журам, зааварт нийцсэн эсэхийг шалгуур болгон авч үзлээ.

1.1. Аймгийн 2023 оны төсвийн төслийн орлогыг Сангийн яамнаас баталсан хязгаартай харьцуулахад 12.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусган ирүүлсэн байна.

Хүснэгт 1. (Сангийн яамны орлогын хянасан хязгаар болон төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөсөн орлогын харьцуулалт)

/мянган төгрөг/

Үзүүлэлт		Сангийн яамны хянасан төсөв	2023 оны төсвийн төсөл	Сангийн яамнаас хянасан зөрүү	Өөрчлөлтийн хувь
№	ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	52,623,990.4	64,662,498.0	12,038,507.6	0.2
	ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО	34,680,887.6	44,518,688.0	9,837,800.4	0.3
1.	Татварын орлого	31,110,100.0	36,267,100.0	5,157,000.0	0.2
1.1	Орлогын албан татвар	23,600,000.0	23,600,000.0	-	-
1.2	Хөрөнгийн албан татвар	1,953,100.0	2,037,100.0	84,000.0	0.0
1.3	Бусад татвар (Төлбөр, хураамж)	5,557,000.0	10,630,000.0	5,073,000.0	0.9
2.	Татварын бус орлого	3,570,788.0	8,251,588.0	4,680,800.0	1.3
2.1	Нийтлэг татварын бус орлого	3,570,788.0	3,613,788.0	43,000.0	0.0
2.2	Хөрөнгийн орлого	-	-	-	-
2.3	Тусламжийн орлого	-	4,637,800.0	4,637,800.0	-
2.4	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	17,943,103.0	17,943,103.0	-	-
3.	Харилцах дансны урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	2,200,707.0	2,200,707.0	-

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөл

Аймгийн төсвийн тэнцвэржүүлсэн ба тусламжийн орлогыг 12.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхдээ хөрөнгийн албан татварын орлогод хамаарах үл хөдлөх албан татварын орлогыг 84.0 сая төгрөг, бусад татварын орлогод хамаарах газрын төлбөрийн орлогыг 1.5 тэрбум төгрөг, газрын дуудлага худалдааны орлогыг 3.7 тэрбум төгрөг, татварын бус орлогод хамаарах Төсвийн байгууллагын өөрийн орлогыг 43.0 сая төгрөг, хандив тусламжийн орлогыг 4.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, урьд оны үлдэгдлээс 2.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцсон байна.

1.2. Аймгийн 2023 оны төсвийн төслийн суурь зарлагыг Сангийн яамнаас баталсан хязгаартай харьцуулахад 2.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн 2023 оны төсвийн төсөлд тусгасан орон нутгийн байгууллагуудын урсгал зардлыг Сангийн яамны хянасан хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 2. (Орон нутгийн байгууллагуудын төсвийн зарлагыг Сангийн яамны хянасан хязгаартай харьцуулсан байдал)

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан төсөв	2023 оны төсвийн төсөл	Зөрүү
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА		12,860,183.9	15,109,747.7	2,249,563.8
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	284,616.2	601,327.1	316,710.9
2	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1,362,444.0	1,068,376.9	(294,067.1)
3	Аймгийн Засаг даргын Тамгын газар	1,712,941.1	2,246,412.0	533,470.9
4	Сумын Засаг даргын Тамгын газар	5,569,719.9	6,711,594.0	1,141,874.1
5	Санхүүгийн хяналт, аудитын алба	183,460.4	262,767.6	79,307.2
6	Орон нутгийн өмчийн газар	180,986.4	222,255.1	41,268.7
7	Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	1,984,112.7	2,121,255.0	137,142.3
7.1	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	1,457,500.0	1,569,748.0	112,248.0
7.2	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	526,612.7	551,507.0	24,894.3
8	Ойн анги /Халхгол, Баян-Уул сум/	101,464.6	165,321.0	63,856.4
9	Хот тохижуулах газар	1,041,821.1	1,121,821.0	79,999.9
9.1	Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ	1,041,821.1	1,121,821.0	79,999.9
10	Аймгийн Засаг даргын нөөцийн сан	250,000.0	400,000.0	150,00.0
11	Аймгийн халамжийн сан	188,618.0	188,618.0	-

Эх сурвалж: Аймгийн 2023 оны төсвийн төсөл

Дээрх хүснэгтээс байгууллага тус бүрийн төсвийн төслийг Сангийн яамны хязгаартай харьцуулан үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын орон тоог Сангийн яамны хянасан хязгаараас 4 орон тоогоор нэмэгдүүлэн төлөвлөсөнд төлөвлөсөн байна. Мөн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийг 239.8 сая төгрөгөөр Сангийн яамны хянасан хязгаараас хэтрүүлэн төлөвлөсөн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-д заасны дагуу 37 төлөөлөгчийг чадавхжуулах арга хэмжээний зардалд тус бүр нь 5.0 сая төгрөг, нийт 185.0 сая төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 54.8 сая төгрөгөөр төлөвлөсөнтэй холбоотой байна.
2. Аймаг болон сумын ЗДТГ, аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба, Орон нутгийн өмчийн газрын орон тоог Сангийн яамны хянасан хязгаараас нэмэгдүүлэн төлөвлөсөнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай туслах үйлчилгээний албан хаагчид багтсан байгаа бөгөөд Сангийн яамнаас хянаж ирүүлээгүйтэй холбоотой байна.
3. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төсөв Сангийн яамны хянасан хязгаараас хэтэрсэн нь өмнөх оноос шилжих байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал тусгагдсантай холбоотой байна.
4. Ойн ангийн төсөв Сангийн яамны хязгаараас хэтэрсэн нь Булган суманд шинээр ойн анги байгуулагдахтай холбоотой байна.
5. Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын төсөв Сангийн яамны хязгаараас хэтэрсэн нь ЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу орон нутгийн авто баазыг шинээр байгуулахтай холбоотой байна.
6. Аймгийн Засаг даргын нөөцийн сангийн төсвийг 2022 оны гүйцэтгэлтэй уялдуулж төлөвлөсөн байна.

ДҮГНЭЛТ:

1. Сангийн яамны хянасан орлогын хязгаарыг баримталж ажилласан байна.
2. Аймгийн 2023 оны төсвийн төсөлд зарлагыг Сангийн яамны хянасан хязгаараас нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

САНАЛ:

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-д заасны дагуу аймгийн ИТХ-ын орон тоог Сангийн яамнаас хянасан хязгаарт багтаах.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг” хэлнэ гэж тодорхойлсон.

Дүрслэл 1 (Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээ)



Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх нийт орлогын 81.5 хувийг татварын орлого, 18.5 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөл

Орон нутгийн төсвийн орлогыг төлөвлөхдөө Татварын орлогын бусад татварын орлогод хамаарах газрын төлбөрийн орлогын төсөөллийг тооцохдоо Дорнод аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 10/01 дүгээр тогтоолоор тогтоосон газрын төлбөрийг тооцох итгэлцүүрийн хувь, төлбөрийн хэмжээг баримтлан төсөвлөсөн боловч 660.3 сая төгрөгөөр дутуу тооцсон байна.

ДҮГНЭЛТ:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг төлөвлөхдөө Сангийн яамнаас ирүүлсэн орлогын доод хязгаарыг баримтлан төлөвлөсөн байна.

САНАЛ:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх газрын төлбөрийн орлогыг 660,3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ:

Аймгийн төсвийн орлогыг Сангийн яамнаас хянасан хязгаарыг баримтлан төлөвлөх, газрын төлбөрийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу газрын төлбөр

ногдуулах итгэлцүүрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тогтоох зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Аймгийн 2023 оны төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөсөн эсэхийг үзэхэд аймгийн ИТХ-ын 2023 оны төсвийн төслийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд багтаан ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагаанд нийт 243.3 сая төгрөгийг төлөвлөснөөс 58.3 сая төгрөгийн зардлыг хэмнэлттэй байхаар төлөвлөөгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аймгийн ИТХ-ын 2023 оны төсвийн зарим урсгал зардлуудыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэмнэлттэй байхаар төлөвлөөгүй байна.

ЗАРДАЛ БУУРУУЛАХ САНАЛ:

Аймгийн ИТХ-ын төсвийн төслийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд тусгасан 58.3 сая төгрөгийг хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчимд нийцүүлэн хасаж төлөвлөх.

БҮЛЭГ 4. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИН

4.1. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Аймгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журам болон бусад холбогдох журам, зааварт нийцсэн эсэхийг шалгуур болгон авч үзлээ.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийг 2023 онд нийт төсөвт өртөг 6,211.1 сая төгрөг байхаар төлөвлөж, 2,824.0 сая төгрөгийг өмнөх оны 14 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар шилжүүлж, шинээр хэрэгжүүлэх 23 төсөл арга хэмжээнд 3,387.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс 2023 онд шилжих төсөл, арга хэмжээнд 1,850.2 сая төгрөг, шинэ төсөл, арга хэмжээнд 2,423.0 сая төгрөг, нийт 4,273.2 санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн орон нутгийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан дараах 2 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилттой уялдахгүй байна. Үүнд:

- 1.2.3.5. “Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын тоног төхөөрөмж (Прокурорын газар)” – 20.0 сая төгрөг
- 1.2.3.8. “Өрхийн эрүүл мэндийн төвд эмнэлгийн тусламж үйлчилгээний автомашин (Асралт-Үйлс ӨЭМТ, Ягаанцээнэ ӨЭМТ Хэрлэн сум)” – 50.0 сая төгрөг

Мөн 1.2.3.5, 1.2.3.7 дахь төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹, 6 дугаар зүйлийн 6.6.6² дахь заалттай нийцэхгүй байна.

¹ 4.1.24. “төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдүүлэх шаардлагыг гаргахгүй байх талаар заасан байна. Гэтэл хөрөнгө оруулалтын жагсаалтын 1.1.5 дахь арга хэмжээ нь өмнөх жилд төрийн аудитаар хянагдаагүй мөн батлагдсан зураг төсвөөс 227.4 сая төгрөгөөр нэмэгдэж, өөрчлөгдсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5³ дахь заалттай нийцэхгүй байна. Мөн тухайн ажлын зураг төсвийг 604.0 сая төгрөг байхаар “Иг” ХХК-иар хийлгэсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5.1⁴, 5.5⁵ дахь заалтыг баримтлаагүй байна.

Хүснэгт 6. “Төсөл арга хэмжээний төсөвт өртөгийн өөрчлөлт”

/сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	2022 оны төсвийн төсөл дэх дүн	2023 оны төсвийн төсөл дэх төсөвт өртөг	Өөрчлөлт	2023 онд санхүүжих дүн
1	1.1.5.	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан орон сууцны барилга (Чулуунхороот сум)	300.0	527.4	227.4	300.0
		Нийт	300.0	527.4	227.4	300.0

Эх сурвалж: 2022, 2023 оны төсвийн төсөл

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.”, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалттай нийцэхгүй, батлагдсан зураг төсөвгүй, техникийн тодорхойлолт, тооцоо судалгаагүй 2 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 1.2.1.3. “Орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар” – 116.8 сая төгрөг
- 1.2.3.7. “Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж, тохижилт (Гурванзагал сум, Хэрлэн сум 2 дугаар сургууль)” – 67.3 сая төгрөг

Орон нутгийн 2023 оны төсвийн төсөл дэх шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд Төрийн аудитын байгууллагаас 2022 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр хянагдаагүй, нэмж батлагдсан мөн төсөвт өртөгт өөрчлөлт орсон дараах 1,016.7 сая төгрөгийн төсөвтэй 7 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 1.1.1. “Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилт” – төсөвт өртөг 95.0 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 25.1 сая төгрөг. Өмнөх жилд төрийн аудитаар хянагдсан боловч төсөвт өртөг өмнөх жилээс 30.0 саяар нэмэгдсэн.
- 1.1.3. “Соёлын төвийн барилгын халаалтын шугамын засвар (Хөлөнбуйр сум)” – төсөвт өртөг 85.3 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 45.3 сая төгрөг, өмнөх жилд төрийн аудитаар хянагдаагүй, нэмж батлагдсан.
- 1.1.7. “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ын нэгдсэн авто гражийн материал” – төсөвт өртөг 450.0 сая төгрөг, өмнөх жилд төрийн аудитаар хянагдсан боловч төсөвт өртөг өмнөх жилээс 156.0 сая төгрөгөөр буурч, өөрчлөгдсөн.

² 6.6.6. тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.

³ 13.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх;

⁴ 5.1. Барилгын тухай хуулийн 25.1, 25.2-т тус тус заасан эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зургийг дараахь байгууллагаар хянуулж, зөвшилцсөн байна:

5.1.1. онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гал түймэртэй тэмцэх нэгж;

5.1.2. мэргэжлийн хяналтын байгууллагын эрүүл ахуйн хяналт хариуцсан нэгж;

5.1.3. инженерийн хангамжийн байгууллага;

5.1.4. авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж (шаардлагатай тохиолдолд).

⁵ 5.5. Зураг төслийн холбогдох хэсгийн зохиогч боловсруулсан зураг төслийг мэргэшлийн зэрэг бүхий архитектор, инженерээр хянуулж, шалгуулсан байна.

- 1.1.8. “Хэрлэн сумын 405, 406 дугаар байранд боловсон ариун цэврийн байгууламж (Хэрлэн сум, 11 дүгээр баг)” – төсөвт өртөг 116.4 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 53.5 сая төгрөг, өмнөх жилд Төрийн аудитаар хянагдаагүй, нэмж батлагдсан.
- 1.1.9. “Сэвсүүлийн голын гарам, хоолой (Дашбалбар сум)” – төсөвт өртөг 90.0 сая төгрөг, өмнөх жилд төрийн аудитаар хянагдаагүй, нэмж батлагдсан.
- 1.1.13. “Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын авто машины сэлбэг хэрэгсэл худалдан авах” – төсөвт өртөг 80.0 сая төгрөг, өмнөх жилд Төрийн аудитаар хянагдаагүй, нэмж батлагдсан.
- 1.1.14. “Дорнод аймагт шинээр байгуулагдах согтуурах, мансуурах донтой өвчтөний албадан эмчилгээний төвд шаардлагатай материал, тоног төхөөрөмж” – төсөвт өртөг 100.0 сая төгрөг, өмнөх жилд төрийн аудитаар хянагдаагүй, нэмж батлагдсан.

ДҮГНЭЛТ:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зөрчин үндэслэлгүй, тухайн шатны төсөвт хамаарахгүй, бодлогын баримт бичигт тусгагдаагүй, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

САНАЛ:

Төсвийн зарлагыг бууруулах нийт 711.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 1.1.5. “Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан орон сууцны барилга (Чулуунхороот сум)” – 527.4 сая төгрөг
- 1.2.1.3. “Орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар” – 116.7 сая төгрөг
- 1.2.3.7. “Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж, тохижилт (Гурванзагал сум, Хэрлэн сум 2 дугаар сургууль)” – 67.3 сая төгрөг

Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх нийт 70.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ байна.

- 1.2.3.5. “Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын тоног төхөөрөмж (Прокурорын газар)” – 20.0 сая төгрөг
- 1.2.3.8. “Өрхийн эрүүл мэндийн төвд эмнэлгийн тусламж үйлчилгээний автомашин (Асралт-Үйлс ӨЭМТ, Ягаанцээнэ ӨЭМТ Хэрлэн сум)” – 50.0 сая төгрөг

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ:

Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль зөрчин үндэслэлгүй, тухайн шатны төсөвт хамаарахгүй, бодлогын баримт бичигт тусгагдаагүй, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн талаар дүгнэлт гаргасан. Төсвийн зарлагатай холбоотой 1,504.2 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг хасах санал өгснөөс 3 төсөл, арга хэмжээг хасаж, 43 хувийн биелэлттэй байна.

4.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУС ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бус шинжтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд санал, дүгнэлт өгөхдөө Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль журам, Сангийн яамны 2023 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлах чиглэл, удирдамжийг шалгуур болгон авч үзлээ.

Орон нутгийн 2023 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын бус шинжтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтаас Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам, Сангийн яамны 2023 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлах чиглэл, удирдамжид нийцээгүй, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах 120.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг хасах санал оруулж байна.

Хүснэгт 7. (Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд нийцээгүй төсөл, хөтөлбөрийн жагсаалт)

		/мянган төгрөг/
д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Санхүүжих дүн
2.69	Аймгийн баяр наадмын зардал	120,000.0
Нийт дүн		120,000.0

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2022 оны 1/2453 тоот албан бичгийн 2 дугаар хавсралт

ДҮГНЭЛТ:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын бус төсөл, арга хэмжээний 10.1 хувь нь урсгал зардлын шинжтэй байна

САНАЛ:

Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам, Сангийн яамны 2023 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлах чиглэл, удирдамжид нийцээгүй ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах 120.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг хасах санал оруулж байна.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ:

Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам, Сангийн яамны 2022 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлах чиглэл, удирдамжид нийцээгүй, төсвийн тооцоо нь зөрүүтэй, хөрөнгө оруулалтын шинжтэй 497.6 сая төгрөгийн 13 арга хэмжээг хасах санал өгснөөс 11 төсөл, арга хэмжээг хасаж 88.2 хувийн биелэлттэй байна.

4.3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Сангийн яам ОНХНС-гаас Дорнод аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 17.9 тэрбум төгрөгөөр тооцож ирүүлсэн байна. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5⁶-д заасны дагуу ОНХС-гийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, 2023 онд уул уурхайн хандив, тусламжаас орох орлогыг 4.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 8. (ОНХС-гийн санхүүжилтийг эх үүсвэр)

				/мянган төгрөг/
Утга	ОНХНС	Уул уурхайн хандив, тусламж	ОНХС-ийн нийт эх үүсвэр	
Суманд	9,797.6	1,391.3	11,188.9	
Аймагт	8,145.5	3,246.5	11,392.0	
дүн	17,943.1	4,637.8	22,580.9	

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөл


Дээрх хүснэгтээс харахад аймгийн орон нутгийн хөгжлийн санд ОНХНС-гаас 8,145.5 сая төгрөг, уул уурхайн хандив тусламжаас 3,246.5 сая төгрөг нийт 11,392.0 сая төгрөг төлөвлөсөн байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд 64 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 12,951.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсвийн төсөл боловсруулсан байна. Үүнд: Өмнөх оноос шилжиж ирсэн 2,446.3 сая төгрөгийн 20 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх хөрөнгө

⁶ тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

оруулалтын 8,169.1 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээ, 2,336.5 сая төгрөгийн 12 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Дүрслэл 1. (ОНХС-гийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг ангиалал):



Дээрх дүрслэлээс харахад 2023 онд ОНХС-гийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын 48.0 хувийг барилга, байгууламж, 18.0 хувийг их засвар, 3.0 хувийг ТЭЗҮ, 9.0 хувийг тоног төхөөрөмж, 22.0 хувийг төсөл, хөтөлбөрт тус тус төлөвлөсөн байна.

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөл

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д нийцсэн эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалттай нийцэхгүй, зураг, төсөвгүй 1.8 тэрбум төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 1.2.2.8, 1.2.2.9 “Чойбалсан хот доторх авто зам” - 1,588.7 сая төгрөг.
- 1.2.2.12 “Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн гадна авто зогсоол” 150.0 сая төгрөг.
- 1.2.2.14 “Улз голын гүүрний далан (Дашбалбар сум)” - 100.0 сая төгрөг.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: “13.3.2 хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;”, ОНХС журмын “4.7.4.Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа, батлан даалт гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;”, “4.7.6 Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.” гэсэн заалтыг тус тус нийцэхгүй дараах төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- 1.2.2.4 “Жимсний мод, хүнсний ногоо тариалахыг дэмжиж усан хангамжийг нэмэгдүүлэх, “Ногоон гудамж” төсөл хэрэгжүүлэх” – 250.0 сая төгрөг

3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгцээ, шаардлага, хүрэх үр дүнг бүрэн тодорхойлоогүй, төсвийн үр ашгийг сайжруулах шаардлагатай 1.8 тэрбум төгрөгийн 1 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- 2.1 “Дижитал аймаг төсөл” – 1,800.0 сая төгрөг

ДҮГНЭЛТ:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн төсөлд тусгагдсан нийт 64 төсөл, арга хэмжээнээс Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, ОНХС-гийн журам зөрчин зураг, төсөв, тооцоо судалгаагүй, хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй 6 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

САНАЛ:

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль, ОНХС-гийн үйл ажиллагааны журамд нийцээгүй нийт 2.1 тэрбум төгрөгийн 4 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хасах саналыг оруулж байна.
2. Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх нийт 1.8 тэрбум төгрөгийн 1 төсөл арга хэмжээний саналыг оруулж байна

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ:

Дорнод аймгийн ОНХС-гийн 2022 оны төсвийн төсөлд аудит хийж зураг төсөвгүй 38.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг хасах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх 1,229.4 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээний саналыг тус тус боловсруулж аймгийн ИТХ-д хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

БҮЛЭГ 5. САНГИЙН ЗАРДЛУУД

5.1.БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДАЛ

Дорнод аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд санал, дүгнэлт өгөхдөө 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж, Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” болон бусад холбогдох журам, зааварт нийцсэн эсэхийг шалгуур болгон авч үзлээ.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2023 онд нийт 2.3 тэрбум төгрөг байхаар төлөвлөж, 280.0 сая төгрөгийг өмнөх оны 3 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар шилжүүлж, шинээр хэрэгжүүлэх 24 төсөл, арга хэмжээнд 2.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс 2023 онд шилжих төсөл, арга хэмжээнд 167.4 сая төгрөг, шинэ төсөл, арга хэмжээнд 1.4 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3 дахь хэсэгт “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт 11. (Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн зураг төсөв, тооцоо судалгаагүй арга хэмжээний жагсаалт зардал)

				/мянган төгрөг/
№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
1	2.1.1	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд хөрсийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр зүлэгжүүлэлт	140,000.0	140,000.0
2	2.2.1	Гадаргын усны нөөц хамгаалах, хиймэл нуурын арчлалт, усны тэжээгдлийг сайжруулах	70,000.0	70,000.0
3	2.2.2	Буйр нуурын эрэг орчмын жуулчны баазууд, отоглох цэгүүдийн хог хаягдал, хөрс, орчны бохирдлыг бууруулах цөлжилтөөс сэргийлэх чиглэлээр	40,000.0	40,000.0

		хэсэгчилсэн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		
4	2.2.11	"Буйр нуурын эрэг орчмын цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах" менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал	120,000.0	120,000.0

ЭХ сурвалж: Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөл

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаар төсвийн жилд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 2.2.7-д "Улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газрууд, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт тэмдэг тэмдэглэгээ хийх зардал" 30.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг зардлын тооцоо, судалгаанд үндэслээгүй байна

САНАЛ:

Техник, эдийн засгийн үндэслэл хангалтгүй, зураг төсөвгүй 370.0 сая төгрөгийн 4 арга хэмжээг хасах

ҮР АШИГ САЙЖРУУЛАХ:

1. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаар төсвийн жилд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 2.2.7-д "Улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газрууд, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт тэмдэг тэмдэглэгээ хийх зардал" 30.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг техникийн тодорхойлолт, ажлын даалгавар ирсэн боловч зардлын тооцоо байхгүй тул сайжруулах саналтай байна.
2. Буйр нуурын эрэг орчмын хамгаалалт, тохижилтын ажлыг хөтөлбөр, төсөл арга хэмжээ болгож үе шаттайгаар хэрэгжүүлэх.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт 81 хувьтай байна.

5.2. АВТО ЗАМЫН САН

Дорнод аймгийн Авто замын сангийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж, Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 312 дугаар тогтоолоор баталсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам" болон бусад холбогдох журам, зааварт нийцсэн эсэхийг шалгуур болгон авч үзлээ.

Аймгийн Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2023 онд нийт 1.5 тэрбум төгрөг байхаар төлөвлөж, 311.4 сая төгрөгийг өмнөх оны 1 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар шилжүүлж, шинээр хэрэгжүүлэх 6 төсөл, арга хэмжээнд 1.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс 2023 онд шилжих төсөл, арга хэмжээнд 103.4 сая төгрөг, шинэ төсөл, арга хэмжээнд 1.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад SCS-XC-D маркийн зөөврийн электрон пүү тоног төхөөрөмж худалдаж авах 198.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төлөвлөсөн байна.

SCS-XC-D маркийн зөөврийн электрон пүүний үнийн талаар www.8008.mn сайтаас судалж үзэхэд ижил загвар, маркийн зөөврийн пүү /автомашины жин хэмжигч/ нь 18.600 юань /гаалийн татварын 15.5% хувийг нэмж тооцоход/ буюу 11.0 сая төгрөг байна. Төсвийн төсөлд төсөвт өртгийг 187.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх хэсэгт “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.7-д “Бодитой байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

САНАЛ:

Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтын 2.1-д тусгасан 198.0 сая төгрөгийн ажилд дахин тооцоолол хийж үр ашгийг сайжруулах саналтай байна..

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ:

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд өмнөх аудитаар 100.0 сая төгрөгийн өртөгтэй “Авто замын дагуу орц, гарц гаргаж засварлах” арга хэмжээг жагсаалтаас хасах, зураг төсвийн дүн, төсөвт өртөг зөрүүтэй хийгдсэн 1.2 дахь 100.0 сая төгрөгийн өртөгтэй “Цемент бетон хатуу хучилттай авто замын засвар /Хэрлэн сум/” арга хэмжээ, 150.0 сая төгрөгийн өртөгтэй “Хамар давааны засвар /Халхгол сум/” арга хэмжээг жагсаалтад зураг, төсвийн дүнгээр тусгаж, төсөвт сайжруулалт хийх шаардлагатай талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

5.3. ХӨДӨӨ АЖ АХУЙН САН

Хөдөө, аж ахуйн сангийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжих 45.0 сая төгрөг, 2023 онд шинээр 888.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Эдгээр арга хэмжээ нь Дорнод аймгийн хөдөө аж ахуйн сангийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж, Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 5/08 дугаар тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн сангийн үйл ажиллагааг зохицуулах журам” болон бусад холбогдох журам, зааварт нийцүүлэн төлөвлөсөн байна.

5.4. ХАЛАМЖИЙН САН

Халамжийн сангийн төсөв 2018 оноос улсын төсөвт шилжихдээ орон нутгийн шинж чанартай гэж үзэж Нийгмийн халамжийн тухай хуулийн 7.1 дэх заалтын 7.1.1 дэх заалтын хүрээнд онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг орон нутгийн төсвөөс санхүүждэг хэвээр үлдээсэн байна.

Аймгийн 2023 оны төсвийн төсөлд халамжийн үйлчилгээ үзүүлэхэд 188.6 сая төгрөг тусгасан нь өнгөрсөн оны батлагдсан төсвөөс 59.8 сая төгрөгөөр илүү төлөвлөжээ.

1. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д дурдагдсан иргэнд олгодог байна. Дорнод аймгийн 2023 оны төсөвт 66.0 сая төгрөг 55 иргэнд олгохоор батлагдаж 11 сарын 28-ны өдрийн байдлаар 44.4 сая төгрөгийг 40 иргэнд

зарцуулж, хүлээгдэж буй гүйцэтгэлээрээ 21.6 сая төгрөг байна. Тайлант он дуусахад ганцхан сарын хугацаа үлдээд байхад нийт батлагдсан санхүүжилтийн 32.7 хувийн үлдэгдэлтэй байна. Халамжийн сангийн төсвийн хуваариас харвал 12 дугаар сард санхүүжилт тавиагүй нь дансны үлдэгдэл болох 21.6 сая төгрөгийн хэмнэлтээр аймгийн 2023 оны төсөвт орлого нэмэгдүүлэхээр байна.

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2-т дурдагдсан иргэд хамрагдах боломжтой байна.

Уг үйлчилгээг 2021 онд 410 иргэнийг хамруулахаар 50.6 сая төгрөг батлагдсанаас 253 иргэн хамруулж 46.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Харин 2022 онд 62.8 сая төгрөгөөр 500 иргэн хамруулахаар төлөвлөснөөс одоогийн байдлаар /2022.11.28/ 343 иргэн хамруулж 52.8 сая төгрөгийг буюу батлагдсан төсвийн 84.1 хувийг зарцуулаад байна. Халамжийн сангийн батлагдсан төсөв нь өмнөх онуудад гүйцэтгэлээрээ хэмнэлттэй гарч байсан байна. Энэ нь зорилтот хэрэглэгчдээс илүү төсөв баталж байсныг харуулж байна.

Дүрслэл 2. (Батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулсан байдал)



Эх сурвалж: Орон нутгийн 2020, 2021, 2022 оны төсвийн гүйцэтгэл.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд батлагдсан төсвөөс 31.6 сая төгрөгийн бодит хэмнэлт үүсэж байна. Үүнээс харахад 2023 онд төсөв хэмнэлттэй байх зарчмыг мөрдөж ажиллаагүй байна.

ДҮГНЭЛТ:

Төсвийг нэмэгдүүлж боловсруулан ирүүлж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдахгүй байна.

САНАЛ:

- Орон нутгийн 2023 оны төсвийн орлогыг халамжийн сангийн үлдэгдэл 59.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.
- Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөлд тусгасан 188.6 сая төгрөгийг бууруулж энэ оны батлагдсан төсвөөр тусгах.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

2022.12.02 № 7/2665
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас
“Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөл”-д өгсөн
аудитын дүгнэлттэй холбогдуулан гаргасан
тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 3 хуудастай

ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН



010622962

ДОРНОД АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ХҮРЭЭНД
ТАЙЛБАР ГАРГАХ НЬ

Нэг: Аймгийн орон нутгийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 1.2.3.5, 1.2.3.8 дахь төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилттой уялдахгүй байна гэсэнтэй холбогдуулан дараах тайлбарыг гаргаж байна Үүнд:

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.15, Прокурорын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.7 дахь заалтад “ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техникийн хэрэгсэл, ажилтныг орон сууцаар хангах зэрэг үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага бүх талын дэмжлэг үзүүлэх”-ээр заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтад хууль хяналтыг байгууллагыг ажиллах нөхцөлөөр хангахаар заасан.

Түүнчлэн “Өрхийн эрүүл мэндийн төвд эмнэлгийн тусламж үйлчилгээний автомашин (Асралт-Үйлс ӨЭМТ, Ягаанцээнэ ӨЭМТ Хэрлэн сум) “Өрхийн эрүүл мэндийн төвд эмнэлгийн тусламж үйлчилгээний автомашин (Асралт-Үйлс ӨЭМТ, Ягаанцээнэ ӨЭМТ Хэрлэн сум) арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.9 дэх заалтад хамаарах төсөл арга хэмжээ бөгөөд нийт хүн амыг нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр хангахын тул эрүүл мэндийн анхан шатны нэгжийн ажиллах нөхцөл баталгааг хангах шаардлагатай тул хасах саналыг хүлээн авах боломжгүй байна. Эдгээр 2 төсөл арга хэмжээ нь бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ байгаа тул санал, дүгнэлтийг хүлээн авах боломжгүй байгаа болно.

Хоёр Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдүүлэх шаардлагыг гаргахгүй байх талаар заасан байна. Гэтэл хөрөнгө оруулалтын жагсаалтын 1.1.5 дахь арга хэмжээ нь өмнөх жилд төрийн аудитаар хянагдаагүй мөн батлагдсан зураг төсвөөс 227.4 сая төгрөгөөр нэмэгдэж, өөрчлөгдсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.51 дахь заалттай нийцэхгүй байна гэжээ.

Дээр дурдсан төсөл арга хэмжээ нь 2022 оны төсвийн төсөлд нийт төсөвт өртөг нь 300.0 сая, 2022-2023 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 09/09 дугаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор төсөвт өртөг өөрчлөгдөж 527,449,5 болж өөрчлөгдсөн төсөл арга хэмжээ болно. Энэхүү ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Чулуунхороот сумын Засаг даргад шилжүүлсэн бөгөөд тус сумын Засаг дарга Үнэлгээний хороо байгуулж тус ажлын тендер шалгаруулалтыг 3 удаа зарласан боловч оролцогч тендер ирүүлээгүй буюу амжилтгүй болсон.

Иймд тус төсөл арга хэмжээтэй холбогдуулан ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй байна.

Гурав: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.”, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалттай нийцэхгүй, батлагдсан зураг төсөвгүй, техникийн

¹ 13.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх;

тодорхойлолт, тооцоо судалгаагүй 2 төсөл, арга хэмжээ байна гэсэн асуудлыг дурдсантай холбогдуулан дараах тайлбарыг гаргаж байна.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.16 дахь заалтад “мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, нэгдсэн эмнэлэг, аймгийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар”-ыг хариуцах чиг үүргийг аймгийн чиг үүрэгт хуульчилсан тул орон нутгийн өмчит бүртгэлтэй “хуучин МСҮТ-ийн гадна шугам, НАА спорт заал, Хэрлэн сумын 1 дүгээр багийн ажлын албаны байр, ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн хуучин барилгуудыг засварлах шаардлагатай байгаа тул энэхүү судалгаа, тооцоонд үндэслэн 116,8 сая төгрөгийг төлөвлөсөн бөгөөд эдгээр барилгыг засварлан сургалтын үйл ажиллагаа болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх шаардлагатай байна.

Иймд дээрх төсөл арга хэмжээний хүрээнд ирүүлсэн санал, дүгнэлтийг хүлээн авах боломжгүй байна.

Дөрөв: Орон нутгийн 2023 оны төсвийн төсөл дэх шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд Төрийн аудитын байгууллагаас 2022 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр хянагдаагүй, нэмж батлагдсан мөн төсөвт өртөгт өөрчлөлт орсон дараах 1,016.7 сая төгрөгийн дараах 7 төсөл, арга хэмжээ байгаа талаар дурьдсан байна. Үүнд

- 1.1.1. “Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилт” – төсөвт өртөг 95.0 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 25.1 сая төгрөг. Өмнөх жилд төрийн аудитаар хянагдсан боловч төсөвт өртөг өмнөх жилээс 30.0 саяар нэмэгдсэн.

- 1.1.3. “Соёлын төвийн барилгын халаалтын шугамын засвар (Хөлөнбуйр сум)”

- 1.1.7. “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ын нэгдсэн авто гражийн материал” – төсөвт өртөг 450.0 сая төгрөг, өмнөх жилд төрийн аудитаар хянагдсан боловч төсөвт өртөг өмнөх жилээс 156.0 сая төгрөгөөр буурч, өөрчлөгдсөн.

- 1.1.8. “Хэрлэн сумын 405, 406 дугаар байранд боловсон ариун цэврийн байгууламж (Хэрлэн сум, 11 дүгээр баг)” – төсөвт өртөг 116.4 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 53.5 сая төгрөг, өмнөх жилд Төрийн аудитаар хянагдаагүй, нэмж батлагдсан.

- 1.1.9. “Сэвсүүлийн голын гарам, хоолой (Дашбалбар сум)” – төсөвт өртөг 90.0 сая төгрөг, өмнөх жилд төрийн аудитаар хянагдаагүй, нэмж батлагдсан.

- 1.1.13. “Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын авто машины сэлбэг хэрэгсэл худалдан авах” – төсөвт өртөг 80.0 сая төгрөг, өмнөх жилд Төрийн аудитаар хянагдаагүй, нэмж батлагдсан.

- 1.1.14. “Дорнод аймагт шинээр байгуулагдах согтуурах, мансуурах донтой өвчтөний албадан эмчилгээний төвд шаардлагатай материал, тоног төхөөрөмж” – төсөвт өртөг 100.0 сая төгрөг, өмнөх жилд төрийн аудитаар хянагдаагүй

Дээрх төсөл арга хэмжээ нь зайлшгүй хэрэгцээ шаардлага бүхий нөхцөл байдлын улмаас 2022 онд хийгдсэн төсвийн зохицуулалт, төсвийн тодотголоор нэмэгдсэн төсөл, арга хэмжээ тул хянагдаагүй болно. Энэхүү төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаруулсан бөгөөд тайлант он эхэлснээс хойш тендер шалгаруулалт явагдсан тул ажлууд бүрэн дуусаагүй буюу гүйцэтгэгч санхүүжилтээ аваагүй тул шилжих хөрөнгө оруулалтын ажлаар оруулсан.

Тав. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.”, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалттай нийцэхгүй 4 төсөл, арга хэмжээ байгаа талаар дурдсан байгаа тул дараах тайлбарыг гаргаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 1.2.2.8, 1.2.2.9 дэх заалтад заасан арга хэмжээний хүрээнд 5 байршилд авто замын шинэчлэл, шинээр зам тавих ажлууд хийгдэх бөгөөд 2020, 2019 оны төсвийг шинэчлэх шаардлагатай байгаа болно.

Мөн ОНХС 1.2.2.12 “Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн гадна авто зогсоол” арга хэмжээний 2021 оны төсөв байгаа бөгөөд хавсралтаар хүргүүлэв.

ОНХС-1.2.2.14 дэх төсөл арга хэмжээг хасах саналыг хүлээн авч, аудитын санал, дүгнэлтийн хэрэгжилтийг ханган ажиллана.

Зургаа: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгцээ, шаардлага, төсвийн үр ашгийг сайжруулахаар “Дижитал Дорнод” төсөл арга хэмжээг дурдсан байх тул тус санал, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган төсвийн үр ашгийг сайжруулж ажиллах болно.

Долоо: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3 дахь хэсэгт “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэсэн заалттай нийцэхгүй байна гэжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.5.2 хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, сааруулах, хамгаалах, тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах гэж заасны дагуу дээрх төсөл арга хэмжээнүүдийг оруулсан бөгөөд энэхүү ажлууд нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолтоор хийгдэх бөгөөд зураг төсөв шаардлагагүй тул техникийн тодорхойлолт, ажлыг даалгаврыг хүргүүлсэн тул санал дүгнэлтийг хүлээн авах боломжгүй байна.

Найм: Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад SCS-XC-D маркийн зөөврийн электрон пүү тоног төхөөрөмж худалдаж авах 198.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төлөвлөсөнтэй холбогдуулан төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх зөвлөмжийг ирүүлсэн. Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг ханган төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг хэрэгжүүлж ажиллана.

Ес: Газрын төлбөрийн орлого 660.3 сая, Халамжийн сангийн үлдэгдэл 59.8 сая нийт 720.1 сая төгрөгөөр төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаар дурдсан байна. Тус санал дүгнэлтийг хүлээн зөвшөөрч хэрэгжилтийг хангаж ажиллана.

ДҮГНЭЛТ:

1. Төсвийн төслийг аймгийн хөгжлийн төлөвлөгөө, Сангийн яамны хянасан хязгаартай уялдуулан боловсруулсан байна.
2. Төсвийн төсөлд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, Төсвийн тухай хуульд заасан шалгуурт нийцүүлэн арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй, төсвийн урсгал зардлыг хэмнэх, төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашигтай, нийгэмд ач холбогдолтой байхаар хүрэх үр дүнг тооцож төлөвлөөгүй төсөл арга хэмжээ байна.
3. Халамжийн сангийн зарлагыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.
4. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 50.3 хувьтай байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн 2023 оны төсвийн төсөлд төсвийн үр ашгийг сайжруулах 2.3 тэрбум төгрөг, төсвийн орлогыг нэмэгдүүлэх 720.1 сая төгрөг, төсвийн зарлагыг бууруулах 3.3 тэрбум төгрөгийн санал, дүгнэлтийг хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг ТЕЗ-д хүргүүлж байна.

1. Төсвийн төслийг хууль, журамд заасны дагуу иж бүрэн тооцоо, судалгаа, нотлох баримтад үндэслэн бодитой төлөвлөж байх.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нийцэхгүй, тухайн шатны төсөвт хамаарахгүй, бодлогын баримт бичигт тусгагдаагүй, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөхгүй байх.
3. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, ОНХС-гийн журам тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж байх.
4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал, Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих арга хэмжээг төлөвлөхдөө зураг, төсөв, тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөж байх.
5. Халамжийн сангийн зарлагыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлттэй байх зарчмыг баримтлан боловсруулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн, зөрчлийг давтан гаргахгүй байх.

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

1. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх – 720.1 сая төгрөг
Үүнд:
 - Газрын төлбөрийн орлого 660.3 сая төгрөг
 - Халамжийн сангийн үлдэгдэл 59.8 сая төгрөг
2. Төсвийн зарлагыг бууруулах – 3,348.4 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ
Үүнд:
 - Төсөвт байгууллагуудын урсгал зардал – 58.3 сая төгрөг
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт – 711.4 сая төгрөг
 - Хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр төсөл арга хэмжээ – 120.0 сая төгрөг
 - Орон нутгийн хөгжлийн сан – 2,088.7 сая төгрөг
 - Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал – 370.0 сая төгрөг
3. Төсвийн үр ашгийг дээшлүүлэх – 2,286.6 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ
Үүнд:
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт – 70.0 сая төгрөг
 - Орон нутгийн хөгжлийн сан – 1,800.0 сая төгрөг
 - Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал – 30.0 сая төгрөг
 - Авто замын сан – 198.0 сая төгрөг
 - Халамжийн сан – 188.6 сая төгрөг

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

1. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасны дагуу аймгийн ЗДТГ-ын зайлшгүй шаардлагатай үйлчилгээний ажилчдын орон тоог хянах талаар Сангийн яаманд уламжлах.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаал



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 05 өдөр


Дугаар А/17

Чойбалсан хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит"-ын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /М.Энхтөр/, аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/ нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Д.Нармандах)-т даалгасугай



Б.БОЛОРТУУЛ

011010100